



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 06 сарын 16 өдөр

Дугаар A/337

Эрдэнэт


Бий биелгээ наадмын зардалд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 07 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд Ховд аймагт зохион байгуулагдах “Бий биелгээ” улсын анхдугаар наадамд Орхон аймгийг төлөөлөн оролцох уран бүтээлчдийн зардалд 1454000 /Нэг сая дөрвөн зуун тавин дөрвөн мянган/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах зардал 1454000 /Нэг сая дөрвөн зуун тавин дөрвөн мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын жагсаалтын Улсын чанартай спорт,соёл урлагийн арга хэмжээг жилд 2-оос доошгүй төрлөөр орон нутагтаа зохион байгуулах арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
06 дугаар сарын 14 ны өдрийн
4/337 дугаар захирамжийн хавсралт

**ХОВД АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ “БИЙ БИЕЛГЭЭ”
УЛСЫН АНХДУГААР НААДАМД ОРОЛЦОХ БИЙ БИЕЛЭЭЧДИЙН
ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Замын зардал - Зай -Зарцуулах шатахуун	км литр	2800 280	1800	504000
2	Жолоочийн зарцуулах хугацаа, өдрийн хөлс	хоног	7	80000	560000
3	Хоолны зардал	хоног хүн	3 13	30000	390000
	НИЙТ				1454000